



Санхүүгийн мэдээллийн Сарилжаа

Хөгжүүлэх хэрэгцээ шаардлага, бодит боломж

П.Оюунбилэг Доктор (Ph.D) Дэд проф

ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны ажлаар манай улсын иргэд, хуулийн этгээд санхүүгийн үнэн зөв, тодорхой, шаардлагад нийцүүлэн боловсруулалт хийгдсэн мэдээллийг хууль ёсны мэдээллийн эх үүсвэрээс зохих төлбөртэйгээр авч ашиглах боломж бүрдүүлэх үүднээс хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг тодруулах, хууль эрх зүйн орчныг судлах, энэ чиглэлээр дэлхийн мэдээллийн зах зээлийн хөгжлийн түршлага болон манай улсын мэдээллийн эх үүсвэрийг харьцуулан үзэж, үүн дээрээ тулгуурлан мэдээллийн арилжаа хөгжүүлэх бодит боломжийг гаргаж харуулахыг зорилоо. Судалгааны үр дүнг харуулбал: (1) Хэрэглэгчийн зах зээлийг судалсан судалгаанд хамрагдагсдын дийлэнхид нь мэдлэг, мэргэжилдээ болон судалгаа шинжилгээний зорилгоор хөрөнгийн зах зээл, санхүүгийн, арилжааны банкуудын мэдээлэл нэлээд хэрэгцээтэй байдаг, мэдээллээ олж авахад хүнд суртал нөлөөлдөг, олж авсан мэдээлэл бүрэн бүтэн, үнэн зөв байж чаддаггүй байна. (2) Мэдээллийн арилжааны хууль эрх зүйн орчныг Монгол улсын хууль, эрх зүйн актын хүрээнд судалж үзэхэд төрийн байгууллагаас түүний эзэмшилд байгаа мэдээллийг авах эрхийн харилцааг зохицуулсан нааштай заалтуудтай, мэдээллийн үйлчилгээ үнэ төлбөртэй байх

талаар тусгагдсан хууль гарсан эерэг талтай ч энэ харилцаа нь зөвхөн төрийн байгууллагад хамааралтай нь учир дутагдалтай байна. (3) Дэлхийн мэдээллийн зах зээлийн хөгжилтэй өөрийн орны өнөөгийн түвшинг харьцуулан судлахад мэдээллийн арилжааг зүй зохистой хөгжүүлснээр мэдээллийн тэгш байдал хангагдаж иргэдийн санхүүгийн боловсрол болон бүх түвшинд суралцагсдын мэдлэг чадвар дээшилж, судалгаа, шинжилгээний ажил шинэ шатанд гарч, төр болон хувийн хэвшлийн байгууллагуудын мэдээллийн ил тод байдал хангагдах нөхцөл боломж бүрдэнэ гэсэн дүгнэлтэд хүрсэн болно.

Түлхүүр үгс: Санхүүгийн мэдээлэл, Санхүүгийн мэдээллийн систем, Маркетингийн судалгаа

ABSTRACT

The research paper aims to identify potential opportunities for developing commercial legal sources of information which will charge individuals and legal entities a service fee for providing with accurate, precise and consistently processed financial information. The paper tried to determine customer demands for and examine the legal environment of such information sources in Mongolia and investigated international practices. The research findings are as follows: (1) Most of the respondents involved

in the consumer market survey said they really need various financial information for their work or research including stock market data, micro and macro financial statistics, as well as financial statements of commercial banks, corporations and companies. However, due to bureaucracy and lack of acquaintances in offices responsible for such financial information, they get the necessary information only through media and the internet which in most cases cannot meet their requirements for truthfulness and accuracy. Therefore, 94,3% of respondents who are employees and 90% of them who are students considered it is necessary to establish legally authorized commercial information sources charging a service fee for true and accurate information. (2) As for legal environment regarding commercial information sources, we found out that there is a law on information transparency including clauses which regulate legal relations of access to government information for which they charge; however, it relates only to government organizations. Consequently, the research identified a real demand for legalizing commercial information sources run by an individual person or a legal entity. (3) As international experiences state, the appropriate development of commercial information sources provides equal access to financial information which in turn enhances financial education of public, promotes research work to a new arena and ensures information transparency in both public and private enterprises.

Keywords: Financial Information, Financial Information System, Marketing Survey

УДИРТГАЛ

Энэхүү судалгааны зорилго нь мэдээллийн арилжааны хөгжлийн олон улсын туршлагыг судлах, манай оронд мэдээллийн арилжаа хөгжүүлэх хэрэгцээ шаардлага байгаа эсэхийг тодорхойлох, эдгээр судалгааны үндсэн дээр мэдээллийн арилжааг хөгжүүлэх бодит боломжийг гарган харуулах явдал юм. Судалгаанд баримт бичгийн судалгааны арга, асуулга, анкетийн арга, ажиглалт, харьцуулалтын аргуудыг хэрэглэв. Судалгааны ажлын зорилгын хүрээнд мэдээллийн арилжааны хэрэгцээ шаардлагыг тодруулах, хууль эрхзүйн орчныг судлах, олон улсын туршлагыг судлах, эдгээр дээр тулгуурлан санхүүгийн мэдээллийн арилжаа хөгжүүлэх

дүгнэлт, зөвлөмж гаргах зорилт тавьсан болно. Мэдээллийн арилжааны хэрэгцээ шаардлагыг тодруулах үүднээс Улаанбаатар хотод байрлах санхүүгийн байгууллагууд, санхүү эдийн засгийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг их дээд сургуулиудаас зорилтот түүвэрлэлтэд, санхүүгийн байгууллагуудад ажилладаг албан хаагч, ажилтан, санхүү эдийн засгийн чиглэлээр сурдаг оюутнууд санамсаргүй түүвэрлэлтэд хамрагдлаа. Судалгааны хамрагдах байгууллага гэсэн эх олонлогийн хувьд хамрагдах байгууллагын нийт ажилтны тоо 9436, оюутнууд гэсэн эх олонлогийн хувьд санхүү эдийн засгийн чиглэлээр сурдаг оюутнуудын нийт тоо 5725 байв. Судалгааны түүвэрлэлтийг олон шатат, санамсаргүй түүвэрлэлтийн аргаар алдааны хамгийн бага түвшин буюу $p=0.05$ итгэх муж нь 95%-ийн магадлалтайгаар бодож гаргалаа. Бодолтын дүнд байгууллагын эх олонлогийн хувьд n нь 370, оюутнуудын эх олонлогийн хувьд n нь 360, нийт түүврийн хэмжээ 730 болсон юм. Энэ дагуу судалгаа авч үр дүнг боловсрууллаа. Мэдээллийн арилжааны хууль эрхзүйн орчныг “Үндсэн хууль”, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”, “Төрийн нууцын тухай хууль”, “Хувь хүний нууцын тухай хууль”, “Байгууллагын нууцын тухай хууль”, “Иргэний хууль”, “Цахим гарын үсгийн тухай хууль” болон бусад эрх зүйн актуудын хүрээнд судалж дүгнэсэн болно. Урьд өмнө манай улсад санхүүгийн мэдээллийн арилжааны талаар хийгдсэн судалгаа шинжилгээний материал байхгүй, мэдээллийн арилжааны талаар манай улсын статистикийн байгууллага тоо баримт, мэдээлэл цуглуулдаггүй учраас энэ чиглэлээр бид дэлхийн мэдээллийн зах зээлийг судлан баримжаа болгох шаардлага байгаа юм. Энэ хүрээнд мэдээллийн арилжаа хөгжүүлж байгаа олон улсын болон өөрийн орны хандлагыг судалсан болно. Судалгааны ажил нь онолын, судалгааны, дүгнэлт, ном материалын жагсаалт, хавсралт гэсэн 5 хэсгээс бүрдэж байна. Онолын хэсэгт мэдээллийн арилжааны талаарх тодорхойлолтууд, суурь ойлголтыг авч үзэв. Судалгааны хэсэг манай оронд санхүүгийн мэдээллийн арилжаа хөгжүүлэх хэрэгцээ шаардлага, мэдээллийн арилжааны туршлага гэсэн хэсгүүдээс бүрдэж байна. Эдгээрт мэдээллийн арилжааг хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг судлан, хууль, эрхзүйн орчныг тодорхойлж, олон улсын туршлагыг судалж, дүгнэлт хэсэгт судалгаагаа нэгтгэн

дүгнэж санал, зөвлөмж өгсөн болно.

ОНОЛЫН ХЭСЭГ

Мэдээлэл нь Informatio гэсэн латин үгнээс үүсэлтэй. Мэдээллийн талаар өнөөдрийг хүртэл нэгдсэн нэг ойлголт тодорхойлолтод хүрээгүй, олон янзаар тодорхойлосоор иржээ. Философичид “Мэдээлэл нь мэдэгдлийн түслэмжтайгаар бодит ертөнцийг таних хэрэглүүр юм. Мэдэгдэл нь үг яриа, текст дүрслэл, тоон өгөгдлүүд, зураглал, таблиц гэхчлэн мэдээллийг дүрслэх хэлбэр юм” гэж тодорхойлдог бол, мэдээлэл зүйн шинжлэх ухааны үүднээс “Мэдээлэл нь өгөгдлийг цуглуулах, хадгалах, боловсруулах, дамжуулах аргуудын дүнд бий болж байдаг ойлголт юм” (Захаров 2002, 188х). Эндээс харахад мэдээлэл нь шинжлэх ухааны салбар бүрт өөр өөрөөр тодорхойлогдож болох өргөн утга агуулгатай ойлголт юм.

Харин арилжаа гэдэг нь аливаа зүйлийг өөр нэгэнд худалдах, өөр бусдаас худалдан авах харилцааг тодорхойлдог ойлголт гэж үзэж болох юм. Бид өнөө үед өдөр тутам үнэт цаасны арилжаа, валютын арилжаа, хөрөнгийн арилжаа, цахим арилжаа, арилжааны банк гэхчлэн арилжаа гэдэг ойлголтыг хэрэглэж байна. Харин бидэнд мэдээллийн арилжаа гэдэг ойлголт шинэ зүйл болж байгаа юм.

Мэдээллийн эрх чөлөө гэдэг ойлголт бол аль хэдийн хүний түгээмэл эрхийн хүрээнд тунхаглагдсан ойлголт юм. НҮБ – ын Ерөнхий Ассемблейн анхдугаар чуулга үүлзалтын 59-р тогтоолд “Мэдээллийн эрх чөлөө нь хүний язгуур эрх бөгөөд... НҮБ –аас эрхэмлэдэг хүний бусад эрхийн үндсэн хэмжүүр мөн”¹ гэж заасан байна. Тэгэхээр мэдээллийн эрх чөлөөний үзэл баримтлал дээр мэдээллийн арилжааны ойлголт тулгуурлана гэсэн үг юм.

“Мэдээллийн арилжаа гэдэг нь тодорхой хүрээний зах зээл дээр тодорхой эрхэлсэн байгууллагаар хийгддэг, интернэтэд суурилсан арилжаа юм”². Энэ тодорхойлолтоос үзвэл мэдээллийн арилжааны тодорхой хэрэглэгч байгаад, арилжааг эрхлэн явуулах тодорхой мэргэшсэн байгууллага байгаа бол мэдээллийг арилжиж болдог байна. Манай зарим судлаачид мэдээллийн бизнес гэсэн санааг гаргаж тавьжээ. Тухайлбал, судлаач

Д.Тулгабат “Мэдээллийн арилжаа, түүний үр ашиг монголын хөгжилд нөлөөлөх нь”³ сэдэвт өгүүлэлдээ мэдээллийн эрэлт, нийлүүлэлтийн талаар, энэ төрлийн бизнес хөгжих боломжийн талаар авч үзжээ. Мэдээллийг арилжихад тулгуур нэг ойлголт бол мэдээллийн үнийн асуудал юм. Мэдээллийн үнэ цэнийг тодорхойлж, нэгж үнэ тогтоох судалгаа хийх нь дараагийн гол зорилго байх болно. Дээрх тулгуур ойлголтуудаас нэгтгэн авч үзвэл манай улсад иргэд, хуулийн этгээд, улс орны эдийн засаг, санхүүгийн байдлын талаарх мэдээллээс авхуулаад төрийн болон хувийн хэвшлийн аль ч байгууллагын мэдээллийг хүссэн үедээ хүссэн хэмжээгээр хүссэн хэлбэрээр чөлөөтэй худалдан авч өөрийн ажил мэргэжилд ашиглаж болдог байх шаардлагатай байна.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Онолын үүднээс авч үзэхэд мэдээллийн үйлчилгээ үзүүлэх, мэдээллийг арилжих нь тодорхой хүрээнд, тодорхой мэргэшсэн байгууллагаар интернэтэд суурилан хийгдэх боломжтой асуудал юм. Иймээс манай оронд санхүүгийн салбарт мэдээллийн арилжаа хөгжүүлэх боломж байна уу?, ийм хэрэгцээ шаардлага бодитоор оршин байна уу? гэдгийг тодруулах зорилгыг судалгааны хэсэгтээ тавьсан болно. Энэ зорилгоор хэрэглэгчийн зах зээлийн судалгааг байгууллага, оюутан суралцагсад гэсэн хоёр чиглэлээр хийсэн. (Судалгааны асуулгыг хавсралтаас үзнэ үү.)

Санхүүгийн мэдээллийн хэрэгцээ шаардлагыг тодруулах энэхүү судалгаанд ажилтны түүвэр олонлогт санхүүгийн байгууллагуудын 26 төрлийн мэргэжлийн (мэргэжлийн бүтцийг хавсралтаас дэлгэрүүлж үзнэ үү) 370 ажилтан (хүснэгт №1), оюутны түүвэр олонлогт их дээд сургуулиудын 31 төрлийн мэргэжлээр (мэргэжлийн бүтцийг хавсралтаас дэлгэрүүлж үзнэ үү) сурч байгаа 360 оюутан оролцоноос (хүснэгт №2) 131 эрэгтэй, 239 эмэгтэй ажилтан, 120 эрэгтэй, 240 эмэгтэй оюутан байна. Насны бүтцийн хувьд 25 хүртэлх насны оюутнууд 84,7%-ийг эзэлж байгаа бол, нийт ажиллагсдын 93%-нь 21-40 насны ажилтнууд байжээ.

1 Х.Наранжаргал “Ил тод байдлыг хангах эрх зүйн орчин” илтгэл, ННФ

2 http://en.wikipedia.org/wiki/Commercial_Information_Exchange

3 <http://www.slideshare.net/batnasanb/ss-31160404>

Санхүүгийн мэдээллийн арилжаа хөгжүүлэх хэрэгцээ шаардлага, бодит боломж

Хүснэгт №1. Байгууллагууд, ажилтны түүвэр
Хүснэгт №2. Их дээд сургуулиуд, оюутны түүвэр

Нэрс	Тоо	Хувийн жин
Даатгалын компани нийт:	74	20.0%
Ард	12	3.2%
Бодь	14	3.8%
Монгол	14	3.8%
Миг	14	3.8%
National life	8	2.2%
Тэнгэр	12	3.2%
Банк нийт:	222	60.0%
Хаан	50	13.5%
Хадгаламж	50	13.5%
Капитал	22	5.9%
Төрийн банк	50	13.5%
Голомт	50	13.5%
ББСБ	28	7.6%
БДК	22	5.9%
ХЗХ	24	6.5%
Нийт	370	100.0%

Нэрс	Тоо	Хувийн жин
МУИС, ЭЗС	72	20.0%
СЭЗДС	72	20.0%
КтМС	36	10.0%
Их засаг их сургууль	36	10.0%
Хүмүүнлэгийн ухааны их сургууль	72	20.0%
Хөдөө Аж Ахуйн их сургууль	72	20.0%
Нийт	360	100.0%

Судалгааны үр дүнгээс танилцуулбал, Санхүүгийн мэдээлэл хэр их хэрэгцээтэй байдаг талаар асуухад оюутнуудын 1,7% огт хэрэг болдоггүй, 41,9% их хэрэг болдог гэж хариулсан бол ажилтнуудын 1,4% нь огт хэрэг болдоггүй, 60,5% нь их хэрэг болдог гэж хариулснаас үзэхэд байгууллагын ажилтнуудад мэдээллийн хэрэгцээ шаардлага илүү их байдаг байна. Мэдээ, мэдээллийг ихэвчлэн ямар зорилгоор ашигладаг тухай асуултад мэдлэг боловсролоо дээшлүүлэх (ажилтнуудын 58,6%, оюутнуудын 72,4%), судалгаа шинжилгээнд хэрэглэх (ажилтнуудын 45,8%, оюутнуудын 37%) зорилго хэрэглэгчдэд тулгамддаг байна. Харин өрсөлдөгчөө судлах зорилгоор ажилтнуудын 23,43%, оюутнуудын 5,1% л мэдээлэл хэрэг болдог гэсэн бол, хөрөнгө оруулалтын зорилгоор ажилтнуудын 16,3%, оюутнуудын 10,8% мэдээлэл авдаг гэжээ. Санхүүгийн ямар төрлийн мэдээлэл хэрэгцээтэй байдаг талаар тодруулахад (хүснэгт №3) хөрөнгийн зах зээлийн мэдээлэл нэлээд хэрэгцээтэй байгаа нь ажиглагдаж байгаа юм. Энэ нь манай улсын засгийн газраас иргэддээ амлаж байгаа хөрөнгө, хувьцаатай холбоотой байж магадгүй юм. Дараа нь ажилтнуудад макро санхүүгийн мэдээлэл хэрэгцээтэй байгаа бол оюутнуудад татварын болон микро түвшний компанийн болон банкны мэдээлэл илүү хэрэг болдог байна. Харин бидний таамаглаж байсан байгууллагын микро түвшний санхүүгийн төлөв байдлын мэдээлэл харьцангуй бага шаардагддаг гэсэн үр дүн гарчээ.




Хүснэгт №3. Санхүүгийн мэдээллийн ангилал/тоо, хувь/

	Ажилтнууд		Оюутнууд			
	N	%	хувь	N	%	хувь
Банкны микро түвшний	122	13,0	33,1	120	14,7	33,6
Банкны макро түвшний	118	12,6	32,0	77	9,4	21,6
Макро санхүүгийн	137	14,6	37,1	114	13,9	31,9
Хөрөнгийн зах зээлийн	179	19,1	48,5	166	20,3	46,5
Татварын	128	13,7	34,7	125	15,3	35,0
Даатгалын	129	13,8	35,0	112	13,7	31,4
Бусад	33	3,5	8,9	14	1,7	3,9
	937	100	253,9	819	100	229,4

Мэдээлэл олж авахад тохиолддог бэрхшээлүүдийг байршил, албан тушаал танилын хүрээ, хүнд суртал, мэдээлэл өгөгчийн мэдлэг гэсэн ангилалаар асуухад санал асуулгад оролцогсад нэгэн дуугаар хамгийн том бэрхшээл нь **хүнд суртал** (ажилтнуудын 38,3%, оюутнуудын 52,3%) гэсэн хариултыг өгчээ. Дараа нь мөн л хоёулаа мэдээлэл өгч байгаа хүний мэдлэгээс (ажилтнуудын 36,1%, оюутнуудын 32,4%) хүндрэл бэрхшээл үүсдэг болохыг баталжээ. Эндээс дүгнэхэд, мэдээлэл өгч байгаа хүмүүс мэдээллийнхээ талаар мэдлэг багатай, боловсруулалт хийж чаддаггүйгээс хүмүүсийн хэрэгцээг хангах нь бага байдаг талтай болов уу. Харин танил тал, албан тушаал тийм их биш ч тодорхой нөлөө үзүүлдэг байна. Бусад гэсэн хариултыг 33(3.5%) ажилтан, 14(1.7%) оюутан өгсөн байгаагаас үзэхэд бидний асуугаагүй хүндрэл бэрхшээл бас тодорхой хэмжээгээр байжээ гэж үзэж байна. Мэдээлэл олж авахад зарцуулдаг хугацааг авч үзэхэд ихэвчлэн 1-4 хоногт мэдээллээ олж авдаг байна. Мэдээлэл олж авах хугацаа бага байгаа нь сайшаалтай хэдий ч мэдээллийг хаанаас олж авч байгаатай уялдуулан авч үзэх нь зүйтэй болов уу.


Мэдээллийг хаанаас ихэвчлэн олж авдаг талаар (Зураг №1) тодруулахад гол суваг нь зурагт, хэвлэл, интернэт, хэрэглэгчийн ажиллаж суралцдаг байгууллага байдаг байна. Мэдээллийн үйлчилгээний гадаадын байгууллагаас болон мэдээллийн холбогдох байгууллага, албан тушаалтнаас мэдээлэл бараг авдаггүйгээс мэдээлэл үнэн зөв, чанартай, эргэлзээгүй байж чадахгүй юм.

Зураг №1. Мэдээлэл олж авдаг сувгуудын ангилал /нэр, тоо/



Олж авсан мэдээлэл хэрэгцээг нь хангадаг эсэх, мэдээлэл шаардлага хангахгүй байгаа бол шалтгааныг тодруулахад шаардлага хангадаггүй (ажилтнуудын 59,2%, оюутнуудын 53,1%) гэж ихэнх нь хариулсан ба ихэвчлэн мэдээлэл бүрэн олддоггүй гэсэн хариултыг өгсөний зэрэгцээ мэдээлэл олон жилийн давтамжтай байж чаддаггүй, бодитой үнэн зөв эсэх нь эргэлзээтэй, байгууллагын мэдээлэл нууцлагдмал байдаг зэрэг бэрхшээлүүдийг тоочжээ. Мэдээллийн хэрэгцээ шаардлага хангаж байгаа байдлыг мэдээлэл олж авсан хугацаатай нь уялдуулан судлахад урвуу хамаарал ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл мэдээлэл олж авахад бага хугацаа зарцуулахын хэрээр хэрэгцээ шаардлага хангадаггүй байдал ажиглагдаж байна.

(Зураг №2.)



Зураг №2. Мэдээлэл олж авах хугацаа болон хэрэгцээ хангах байдлын хамаарал

Олж авсан мэдээлэл алдаатай байх тохиолдол байсан эсэх талаар асуухад ажилтнуудын 48,6%, оюутнуудын 50,3% тийм хариулт өгчээ. Алдаатай мэдээлэл олдсон тохиолдолд ямар арга хэмжээ авдаг талаар тодруулж асуухад өөр эх үүсвэрээс дахин мэдээлэл хайдаг гэсэн хариултыг ихэвчлэн өгсөн бол, уул мэдээллээ хэрэглэдэггүй, бухимдаад өнгөрдөг, өөрөө зөв болгож засдаг гэсэн хариултууд ч өгчээ. Мэдээлэл авахыг хүсдэг сүвгуудын талаар асуухад судалгаанд хамрагдагсад хамгийн тохиромжтой гэж интернэт сайт, э-мэйл, онлайн хэлбэрүүдийг сонгожээ. Энэ нь орчин үеийн мэдээллийн хэрэгслийн дамжуулалтын хэрэгслүүдийг манай оюутнууд, мэргэжилтнүүд сайн эзэмшиж байгааг харуулсан байна. Хэвлэмэл байдлаар мэдээлэл түгээх уламжлалт арга хэрэгслийг ч бас сонирхож байна. Харин сүлжээ болон дискээр авахыг бараг хүсдэггүй байна. Санхүүгийн мэдээллийн үйлчилгээ бий болгох бодит шаардлагыг тодруулахад ажилтнуудын 94,3%, оюутнуудын 90,3% дэмжинэ гэж хариулжээ. Харин ажилтнуудын 2,73%, оюутнуудын 4,2% нь хариулаагүй байна. Эндээс үзэхэд манай санхүүгийн салбарт мэдээллийн хэрэгцээ шаардлага бодитой оршин байгаа юм. Мэдээллийн үйлчилгээ авахдаа ямар шаардлага тавих талаар үнэн зөв, баталгаатай мэдээллээр цаг алдалгүй түргэн хангагдахыг хүсч байна. Харин өөрсдийнх нь нууцлалтай холбоотой, бас боловсруулалт хийгдсэн байх асуудал нэн чухал биш байна. Энэ асуултыг гүнзгийрүүлэн мэргэжлийн хүмүүсийн боловсруулалт хийсэн мэдээллээр хангагдахыг хүсч байгаа эсэхийг асуухад ажилтнуудын 89,2%, оюутнуудын 91,7% тийм гэсэн хариулт өгчээ. Мэдээллийн үйлчилгээний байгууллага бий болбол юуг нь илүү анхаарч үйлчлүүлэх талаар асуухад хэрэглэгчид мэдээллийн үнэн зөв, хууль ёсны байхад гол анхаарлаа хандуулах бол дараа нь эх сурвалжийг оюутнууд, мэдээлэл зөв боловсруулагдсан байдлыг ажилтнууд чухалчилжээ. Санал асуулгын дараа 20 ажилтан, 35 оюутныг сонгон авч ярилцлага хийсэн. Ярилцлагаар мэдээллийн үнэ, цэнэ болон ямар нэгэн төлбөр төлөхөд бэлэн байгаа эсэхийг тодруулахад дийлэнх нь (ажилтнуудын 51,6%, оюутнуудын 50,3%) төлбөр төлж болно гэсэн хариулт өгчээ.

• **Мэдээллийн арилжаа хөгжүүлж буй туршлага**

Өнөөдөр бид санхүүгийн аль ч түвшний мэдээллийн хүрээнд өөрийн орны статистик тоо баримтыг ашиглахаас гадна ОУ-ын байгууллагууд, мэдээллийн агентлагуудын гаргаж буй мэдээллийн эх үүсвэрүүдийг ашиглаж байна. Дэлхийн мэдээллийн зах зээл дээрх хөрөнгийн биржийн мэдээлэл, арилжааны мэдээлэл, ажил хэргийн мэдээлэл өнөөгийн байдлаар бидний гол мэдээллийн эх үүсвэр болоод байна. Дэлхийн санхүүгийн мэдээллийг мэдээллийн томоохон эх сурвалжууд болох Reuters, Dow Jones Telerate, Tenfore, Bloomberg агентлагуудаас авч байна. Дэлхийн зах зээлийн мэдээлэл нь олон нийтэд бус голдуу мэргэжлийн хүрээнд түгээгддэг онцлогтой. Эдгээр эх сурвалжийн мэдээлэл нийлүүлэлт нь электрон гэрээ хийх боломжоор хангагдсан байдаг байна. Бизнесийн мэдээлэл түгээж байгаа дэлхийн жишигт интернэт ихээхэн үүрэгтэй ч мэдээллийн баазыг компакт диск ашиглан түгээх хэлбэр мөн уламжлагдан хадгалагдаж байна. Мэдээлэл түгээх эдгээр хэрэгслүүдийн алианаар нь ч түгсэн санхүүгийн мэдээллийн бааз нь мэдээлэл авахад хялбар, шууд хэрэглэж болохоор хүснэгтэн хэлбэрт бичигдсэн, асар их хэмжээний өгөгдөл үзүүлэлтийг агуулсан байдаг. Олон улсад Ройтерс⁴ болон Блүмберг агентлагийн мэдээллүүд ихээхэн нэр хүндтэй байсаар байна. Эдгээр нь үнэт цаас, валютын болон барааны зах, улс төр ба бизнесийн мэдээ, бусад агентлаг хэвлэлүүдийн мэдээ, олон улсын ба засгийн газрын байгууллагуудын мэдээллийг цаг тухай бүрт нь өгч чаддаг. Санхүүгийн зах зээлийн мэдээллийг маш өргөнөөр нийлүүлдэг өөр

4 www.reuters.com

нэг систем бол Dow Jones Telerate компани юм. Энэ системийн үзүүлдэг үйлчилгээнд электрон дилинг, мэдээ дамжуулалт, электрон шуудан, тусгай сэдвийн нийтлэл, мэдээллийн бааз ашиглах эрх, мэдээлэл өгөх үйлчилгээ, биржийн үйлдлүүдийн программ хангамж багтдаг байна. Бизнесийн мэдээний хувьд өргөн дэлгэрсэн тогтмол хэвлэлүүд ихээхэн үүрэгтэй юм. Хамгийн нэр хүнд бүхий хэвлэлд өдөр тутмын "Financial Times", "Wall Street Journal", "Daily Commerce", долоо хоног тутмын "Economist", "Businessweek", "The Banker", сар бүрийн "Financial Executive", "Institutional Investor", "Stock Market Magazine" зэрэг хэвлэлүүд багтана. Манай хойд хөрш Орос Улсад л гэхэд сүүлийн жилүүдэд энэ чиглэлээр олон хэвлэлүүд гарч эхэлснээс хамгийн өргөн тархсан өдөр тутмын "Ведомости", "Коммерсант-дэйли", "Деловой Экспресс", долоо хоног тутмын "Финансовые Известия", "Финансовое Дело", "Финансовая газета", "Деньги", сар тутмын "Банковское Дело Рынок Ценных Бумаг", "Финансовый Менеджмент", "Финансист" зэрэг хэвлэлүүд багтна. Манай улсын хувьд эдийн засгийн ерөнхий төлвийг харуулсан макро түвшний мэдээллүүд Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ), Монгол банк, Сангийн яам, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим (МҮХАҮТ) зэрэг байгууллагуудаас олон нийтэд болон мэргэжлийн тодорхой хүрээнд, албан хэрэгцээнд боловсруулагдан гарч байна. Тухайлбал, Монгол банкнаас⁵ арилжааны банкуудын тайлан тэнцэл, зээлийн тайлан, мөнгө, хадгаламж, зээл, төв банкны үнэт цаасны хүү, бодлогын хүү, гадаад секторын мэдээ мэдээллүүд, ҮСХ⁶ -ноос мөнгө, зээл, үнэт цаасны зах зээл ханшийн мэдээ, мэдээлэл, статистикийн бусад мэдээллүүд нэлээд өргөн хүрээнд гарч байгаа юм. Мөн энэ чиглэлээр "Санхүүгийн Мэдээ", "Санхүүгийн Лавлах мэдээ", "Бизнес Ньюс", "Бизнес Таймс", "Санхүү Банкны Мэдээлэл сонинүүд", "Санхүү, Бүртгэл Аудит", "Мөнгө Санхүү", "Хөрөнгө Оруулалт Хөгжил", "Монголиан Экономист" (англи, монгол хэлээр) зэрэг сэтгүүл хэвлэгдэн гарч, МҮОНТ, ВТV, Боловсрол, TV9, TV5 "Eagle", "Bloomberg" Mongolia зэрэг телевиз эдийн засаг, бизнесийн мэдээлэл бэлтгэн явуулж байгаа нь сайшаалтай байна. Мөн олон улсад нэр хүндтэй "Bloomberg Business

5 Монгол банкны статистикийн эмхэтгэлүүд

6 ҮСХ-ны мэдээллийн сан

Week", "EuroMoney", "Global Finance", "The Economist" зэрэг хэвлэлүүдийг үндэсний тогтмол хэвлэл захиалгад оруулж нийтийн хүртээл болгож байгаа юм.

Энэ бүгдээс нэгтгэн дүгнэж үзвэл манай улсын санхүүгийн салбарт үнэн зөв мэдээллээр хүссэн цагтаа хангагдах боломж тулгамдсан асуудал болж байна. Дэлхийн мэдээллийн эх сурвалжуудын түүхэн хөгжил, манай орны санхүү, эдийн засгийн байгууллагуудын мэдээлэл бэлтгэн гаргаж байгаа туршлагауд, телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслийн энэ чиглэлээрх нийтлэлийн бодлого дээр үндэслэн зөв зохион байгуулалттай, мэргэжлийн байгууллагыг үүсгэн байгуулж санхүүгийн мэдээллийн арилжааны үндэс суурийг тавих бодит боломж байгаа юм.

ДҮГНЭЛТ/ЗӨВЛӨМЖ

Манай улсын санхүүгийн байгууллагуудад ажиллаж буй хүмүүст, энэ мэргэжлийг эзэмшихээр суралцаж буй оюутан залууст үнэн зөв, найдвартай хууль ёсны мэдээллээр хангагдаж судалгаа шинжилгээний ажилд болон өөрийн мэдлэг мэргэжлээ дээшлүүлэхэд ашиглах асуудал нэн чухал, тулгамдсан асуудал болж байна. Тэдний хувьд өнөөдрийн байдлаар мэдээллээр хангагдахад тулгарч байгаа гол бэрхшээл бол яах аргагүй хүнд суртал байна. Мэдээллийн хувьд хамгийн түгээмэл хүнд суртал бол байгууллагын нууц гэдэг ойлголтын дор бүх мэдээллээ хамруулдаг, судалгаа, олон нийтэд нээлттэй мэдээлэл гэдэгт юуг ойлгох нь тодорхойгүй байдаг явдал юм. Иймээс мэдээллийн нууцлалын зэрэглэл тогтоох, нийтэд болон тусгай хүрээнд нээлттэй байх мэдээллийг тодорхойлдог олон улсын практикт тулгуурласан арга аргачлал зайлшгүй хэрэгтэй болж байна.

Ер нь мэдээлэл олж авах эрх, эрх чөлөөгөөр хүн бүр тэгш хангагдах ёстой байдаг. Энэ талаар манай төрийн бус байгууллагуудад зарим судалгаа хийгдэж байна. Монголын нээлттэй нийгэм форумас "Мэдээллийн эрх чөлөө", Глоб интернэйшнэл төрийн бус байгууллагаас "Төрийн нууц ба мэдээллийн эрх чөлөө" судалгааны ажлууд хийгдсэн. Хэрэв албан тушаалтан, ажилтан мэдээлэл өгөхөөс татгалзвал шалтгаанаа заавал нотлох ёстой. Хувь хүн, байгууллага мэдээллээр хангагдах хууль эрх зүйн орчин өнөөдөр маш хангалтгүй байна. Монгол Улсын "Үндсэн хууль"-ийн Арван зургаадугаар зүйлийн 17-д Монгол

Улсын иргэн нь төр, түүний байгууллагаас хууль ёсоор түсгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй гэж заасан. 2011 оны 6 сард Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль батлагдсан ч энэ хууль нь улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагад хамааралтай, өөрөөр хэлбэл төрийн байгууллагын мэдээллээр хангагдах эрх зүйг хуульчилсан юм. Мэдээллийн эрх чөлөөний хуультай орнуудад мэдээлэл өгөхөөс үндэслэлгүй татгалзсан албан тушаалтан, албан хаагчид захиргааны хариуцлага ногдуулдаг байна⁷. Манай улсад Мэдээллийн эрх чөлөөний хууль их үгүйлэгдэж байна. Ийм хуулийн төслийг 2007 онд анх санаачилсан байдаг ч өнөөг хүртэл бодитой ажил болж чадаагүй байна. Иймд энэхүү хуулийг яаралтай батлуулах талаар холбогдох байгууллагууд идэвхи санаачилгатай ажиллах шаардлагатай байгаа юм.

Манай улсад олон улсын мэдээллийн ангиллаар макро эдийн засгийн болон статистикийн мэдээлэл нэлээд өргөн хүрээнд боловсруулагдан гарч олон нийтийн хэрэглээ болж чадаж байна. Харин микро түвшний санхүүгийн мэдээллүүд, банк, хөрөнгийн биржийн, арилжааны мэдээллүүдээр хангагдахад хүндрэлтэй байгаа юм. Түүнчлэн аль ч түвшний мэдээллийг эрдэм шинжилгээ, судалгааны ажил, бүтээлд ашиглах хэмжээнд өргөн утгаар нь авах боломж мөн хязгаарлагдмал байна.

Энэ бүгдээс нэгтгэн дүгнэвэл, манай улсад хувь хүн, байгууллага мэдээллээр хангагдах хэрэгцээ шаардлага өдөр ирэх бүр өсөн нэмэгдэж, мэдээлэлгүйгээр сурч, ажиллах нөхцөл боломж түвэгтэй болж байна. Иймээс мэдээллийг зохих төлбөртэйгөөр үнэн зөв, бодитой, цаг алдалгүй, зөв боловсруулж өгдөг албан ёсны эх үүсвэр, субъект (судалгаанд оролцсон ажилтнуудын 94,3%, оюутнуудын 90,3% хүсч байгаа) бий болгох шаардлагатай байна. Үүнийг энэхүү судалгааны ажил тод харуулж өгсөн гэж дүгнэж болох юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Википедия 2013, Электрон эх үүсвэр <http://ru.wikipedia.org/wiki>
- Монгол Улсын Их Хурал 2011, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай”, Монгол Улсын хууль, Электрон эх үүсвэр <http://www.legalinfo.mn/law/details/375?lawid=375>
- Монгол Улсын Их Хурал 2011, “Цахим гарын үсгийн тухай”, Монгол Улсын хууль, Электрон эх үүсвэр <http://www.legalinfo.mn/law/details/574?lawid=574>
- Монгол Улсын Их Хурал 2002, “Иргэний хууль”, Монгол Улсын хууль
- Монгол Улсын Их Хурал 1995, “Хувь хүний нууцын тухай”, Монгол Улсын хууль
- Монгол Улсын Их Хурал 1995, “Байгууллагын нууцын тухай”, Монгол Улсын хууль
- Монгол Улсын Их Хурал 1995, “Төрийн нууцын тухай”, Монгол Улсын хууль
- Монгол Улсын Их Хурал 1993, “Монгол Улсын Засгийн газрын тухай”, Монгол Улсын хууль
- Глоб интернэйшнэл төрийн бус байгууллага 2006, “Төрийн нууц ба мэдээллийн эрх чөлөө”, судалгааны ажил, Электрон эх үүсвэр <http://www.globeinter.org.mn/images/upld/1189333442reportm-last.pdf>
- Нээлттэй нийгэм форум 2006, “Ил тод байдлыг хангах эрх зүйн орчин” хурлын эмхэтгэл, МОНГОЛ АДМОН, Улаанбаатар
- Монголын нээлттэй нийгэм форум 2005, “Мэдээллийн эрх чөлөө” судалгааны ажил, СОЁМБО ПРИНТИНГ, Улаанбаатар
- Титоренко Г.И. 2009, “Экономические информационные системы”, Москва
- Чимгээ.Д 2008, “SPSS 21.0” хэрэглэгчийн гарын авлага
- Аюурзана.Ц 2008, “Санхүүгийн менежмент”, сурах бичиг, УБ
- Бат-Өлзий.Ж 2007, “Санхүүгийн менежмент”, сурахбичиг, УБ
- Оюунбилэг.П 2007, “Мэдээллийн систем”, гарын авлага,УБ
- Jessica Keyes 2006, “Financial Services Information Systems”
- Захаров В. П. 2002, Информационные системы, Учебное пособие, Москва
- Монгол банкны статистикийн эмхтгэл, 2008-2012
- ҮСХ статистикийн эмхтгэл, 2008-2012
- ҮСХ “Шинжилгээ судалгааны ажил хийхэд баримтлах арга зүй” зөвлөмж, 2010

⁷ Нээлттэй нийгэм форум “Мэдээллийн эрх чөлөө” судалгааны ажил 39 р тал

Ашиглагдсан интернэт эх үүсвэрүүд

www.mongolia-finance.mn

www.reuters.com

www.tenfore.net

www.nso.mn

www.mongolpost.mn

<http://economics.gogo.mn/news/79829>

<http://www.mongolnews.mn/i/38520>

www.likeit.mn/news/id/91

www.slideshare.net/MGL_MOSA/2011-16285812

<http://tech.news.mn/content/74794.shtml>

<http://www.mongolbank.mn/liststatistic.aspx?did=5>

<http://economics.gogo.mn/news/list.jsp?cat=8003>

<http://economy.news.mn/contentlist/category26.shtml>

<http://cabinet.gov.mn/images/editor/files/NEGTGEL-1.pdf>

<http://www.legalinfo.mn/annex/details/592?lawid=1527>

<http://www.pwc.com/ip/en/assurance/research-insights/accounting/>

ХАВСРАЛТ

Хүснэгт №4. Ажилтнуудын мэргэжлийн бүтэц\тоо,хувь\

		Тоо	Хувь	Өссөн хувь
1	Нягтлан бодогч	71	19,2	19,2
2	Сэтгүүлч	4	1,1	20,3
3	Даатгалын ажилтан	16	4,3	24,6
4	Менежер	21	5,7	30,3
5	Эдийн засагч	75	20,3	50,5
6	Эрх зүйч	10	2,7	53,2
7	Диллер	1	0,3	53,5
8	Мэд. Сис. Инженер	7	1,9	55,4
9	Хэрэглээний математикч	4	1,1	56,5
10	Санхүүгийн менежер	13	3,5	60,0
11	Бизнесийн менежер	25	6,8	66,8
12	Актуарч	2	0,5	67,3
13	Банкны менежер	14	3,8	71,1
14	ОУХ ны менежер	2	0,5	71,6
15	Програм зохиогч	2	0,5	72,2
16	Үнэлгээний ажилтан	5	1,4	73,5
17	Маркетингийн менежер	3	0,8	74,3
18	Даатгалын эдийн засагч	2	0,5	74,9
19	Хоршооны теллер	24	6,5	81,4
20	Зээлийн мэргэжилтэн	2	0,5	81,9
21	Брокер	18	4,9	86,8
22	Санхүүч	24	6,5	93,2
23	Статистикч	1	0,3	93,5
24	Бизнесийн эдийн засагч	4	1,1	94,6
25	Банкны эдийн засагч	17	4,6	99,2
	Бусад	3	0,8	100,0
		370	100,0	

Санхүүгийн мэдээллийн арилжаа хөгжүүлэх хэрэгцээ шаардлага, бодит боломж

Хүснэгт №5. Оюутнуудын мэргэжлийн бүтэц/тоо,хувь/

		Тоо	Хувь	Өссөн хувь
1	Бизнесийн менежмент	35	9,7	9,7
2	Маркетинг	7	1,9	11,7
3	Бизнесийн менежмент,эдийн засаг	13	3,6	15,3
4	НББ	111	30,8	46,1
5	Компьютер, график дизайн	5	1,4	47,5
6	Англи хэл багш	11	3,1	50,6
7	Аялал жуучлалын менежмент	4	1,1	51,7
8	Эрхзүйч	7	1,9	53,6
9	Сэтгүүлч	4	1,1	54,7
10	Санхүү Менежмент	26	7,2	61,9
11	НББ эдийн засагч	1	0,3	62,2
12	Бизнесийн эдийн засаг	4	1,1	63,3
13	Эдийн засагч	17	4,7	68,1
14	Банкны эдийн засагч	10	2,8	70,8
15	Санхүүч	3	0,8	71,7
16	Э.з математик загварчлал	1	0,3	71,9
17	Статистикч	5	1,4	73,3
18	Санхүү эдийн засаг	12	3,3	76,7
19	Даатгал	12	3,3	80,0
20	Санхүү мэдээлэл зүй	1	0,3	80,3
21	ОУЭЗ	7	1,9	82,2
22	Банк	30	8,3	90,6
23	ОУХ	6	1,7	92,2
24	ЭЗО	4	1,1	93,3
25	Сэтгэл зүйч	4	1,1	94,4
26	Зочид буудлын менежмент	1	0,3	94,7
27	Урлаг судлал	3	0,8	95,6
28	НББ мэдээлэл зүй	8	2,2	97,8
29	Бихевиоризм судлаач	3	0,8	98,6
30	Байгаль хамгаалал, Экологийн менежмент	2	0,6	99,2
31	Англи хэлний орчуулагч	3	0,8	100,0
		360	100	

Асуулга

Зорилт: Бид энэхүү асуулгын хүрээнд санхүүгийн мэдээлэл хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээ, шаардлага түүнд тулгарч буй асуудлуудыг олж мэдэх, мэдээллийн төв байгуулах шаардлага хэрэгцээг тодорхойлоход оршино.

1. Таны нас --
2. Хүйс эрэгтэй эмэгтэй
3. Таны мэргэжил
4. Танд санхүүгийн мэдээлэл хэр их хэрэг болдог вэ?
 - 1) Огт хэрэг болдоггүй
 - 2) Бага зэрэг
 - 3) Дунд зэрэг
 - 4) Их
5. Таны хувьд дараахь мэдээллээс аль нь шаардагддаг вэ?
 - а) Банкны мэдээлэл микро түвшинд

- b) Банкны мэдээлэл макро түвшинд
 - c) Макро түвшний санхүүгийн мэдээлэл
 - d) Микро түвшний санхүүгийн мэдээлэл
 - e) Хөрөнгийн зах зээлийн мэдээлэл
 - f) Татварын мэдээ, мэдээлэл
 - g) Даатгалын мэдээ, мэдээлэл
 - h) Бусад
6. Та санхүүгийн мэдээ, мэдээллийг ихэвчлэн ямар зорилгоор ашигладаг вэ?
- a) Мэдлэг, боловсролдоо ашиглах
 - b) Судалгаа, шинжилгээний ажилд хэрэглэх
 - c) Өрсөлдөгчөө судлах
 - d) Хөрөнгө оруулалтын зорилгоор
 - e)
7. Та мэдээллээ ямар эх сурвалжаас голдуу олж авдаг вэ?
- a) Зурагт , сонин хэвлэл, интернетийн сайтаас
 - b) Мэдээллийн үйлчилгээ үзүүлдэг гадаадын байгууллагаас
 - c) Өөрийн ажилладаг/суралцдаг/ байгууллагаас
 - d) Гадны байгууллагын тухайн мэдээлэлтэй холбоотой албан тушаалтнаас
 - e) Хувь хүнээс / найз нөхөд, гэр бүл .../
 - f) Бусад эх сурвалж
8. Та мэдээллээ олж авахын тулд хэдий хэр хугацаа зарцуулдаг вэ?
- 1) 1 хоног
 - 2) 2-4 хоног
 - 3) 5-аас дээш хоног
9. Танд мэдээлэл олж авахад ямар бэрхшээл тулгардаг вэ?
- a) Байршлын алслагдмал байдал
 - b) Албан тушаал
 - c) Танилын хүрээ
 - d) Хүнд суртал
 - e) Мэдээлэл өгөгчийн мэдлэг
 - f) Бусад.....
10. Таны цуглуулсан мэдээлэл ажил, судалгаагаа гүйцэтгэхэд хангалттай мэдээлэл болж чаддаг үү? / Хэрвээ та 1) хувилбарыг сонгосон бол 12 дугаар асуулт руу очно үү /
- 1) Чаддаг
 - 2) Чаддаггүй
11. Хэрвээ та 10 дугаар асуултын 2) хувилбарыг сонгосон бол яагаад гэдгээ бичнэ үү?
-
12. Таны олж авсан мэдээлэл өөр эх сурвалжаас авсан мэдээлэлтэй таарахгүй/алдаатай/ байх тохиолдол байсан үү? / Хэрвээ та 2) хувилбарыг сонгосон бол 14 дүгээр асуулт руу очно үү /
- 1) Тийм
 - 2) Үгүй
13. Хэрвээ та 12 дугаар асуултын 1) хувилбарыг сонгосон бол, энэ үед та ямар арга хэмжээ авдаг тухайгаа бичнэ үү?
-
14. Та мэргэжлийн хүмүүсийн боловсруулсан санхүүгийн мэдээллийг хэрэглэмээр байна үү?
- 1) Тийм
 - 2) Үгүй
15. Хэрвээ санхүүгийн мэдээлэл өгдөг нэгдсэн төв байгуулагдвал та дэмжих үү?
- 1) Тийм
 - 2) Үгүй
16. Мэдээллийн үйлчилгээний төв ямар байх ёстой гэж та бодож байна вэ?
- a) Үйлчлүүлэгчийн нууцлалыг сайн хамгаалдаг.

Санхүүгийн мэдээллийн арилжаа хөгжүүлэх хэрэгцээ шаардлага, бодит боломж

- b) Үнэн зөв баталгаатай мэдээлэл өгдөг.
 - c) Мэдээллийг цаг алдалгүй өгдөг.
 - d) Хүссэн боловсруулалтыг мэргэжлийн өндөр түвшинд хийж өгдөг.
 - e) Бусад
17. Мэдээллийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлэхдээ та юуг илүү их анхаарах вэ?
- a) Мэдээлэл үнэн зөв эсэхийг илүү анхаарна.
 - b) Мэдээллийн эх сурвалжийг илүү анхаарна.
 - c) Мэдээлэл хууль ёсны эсэхийг илүү анхаарна.
 - d) Мэдээлэл зөв боловсруулагдсан эсэхийг илүү анхаарна.
 - e) Бусад
18. Танд мэдээллийг ямар хэлбэрээр авбал илүү хялбар байх вэ?
- a) Интернет сайтаас
 - b) Соронзон бичлэг/дискээр/хэлбэрээр
 - c) Он-лайн хэлбэрээр
 - d) Хэвлэмэл байдлаар
 - e) Сүлжээгээр
 - f) Э-мэйлээр
19. Та санхүүгийн мэдээллийн нэгдсэн төвийн талаар өөрийн бодлыг бичнэ үү
.....

Санал асуулганд оролцсон танд баярлалаа.